

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Уянга сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/171/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Арвайхээр 2022 он</p>	<p>Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253      Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833      Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Аудитор:                      Р.Энхзул Утас: 70323833      Цахим хаяг: EnkhzulR@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Аудитын тайлан .....
- 3.1 Ерөнхий зүйл .....
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Материаллаг байдал.....
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....
- 3.8 Аудитын гол асуудал.....
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
4. Аудитын илрүүлэлт.....
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл

## 1. Аудитын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

УЯНГА СУМЫН ИТХ-ЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
П.ОЖИДМАА ТАНАА

2021.02.25 № 240.  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уянга сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Уянга сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

015030479

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,226,388.00</b>	<b>1,226,700.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	21,688.00	-
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	21,688.00	-
31110	Төгрөг	21,688.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,204,700.00	1,226,700.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	1,204,700.00	1,226,700.00
35420	Аж ахуйн материал	1,204,700.00	1,226,700.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>25,822,085.40</b>	<b>20,673,491.03</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	25,822,085.40	20,673,491.03
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	25,822,085.40	20,673,491.03
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,500,000.00	50,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(33,500,000.00)	(36,333,333.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,470,975.00	11,470,975.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,940,972.31)	(7,881,233.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,527,160.00	5,527,160.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,235,077.29)	(2,610,077.29)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>27,048,473.40</b>	<b>21,900,191.03</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>30,000.00</b>	<b>837,248.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	30,000.00	837,248.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	30,000.00	837,248.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	30,000.00	279,248.00
41311	Цалингийн өглөг		60,000.00
41313	ХАОАТ-ын өглөг		219,248.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	558,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	558,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>27,018,473.40</b>	<b>21,062,943.03</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	27,018,473.40	21,062,943.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	19,286,000.00	19,286,000.00
51101	Өмч: - төрийн	19,286,000.00	19,286,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	5,484,571.59	(470,958.78)
51210	Өмнөх үеийн үр дүн	(15,829,536.99)	5,484,571.59
51220	Тайлант үеийн үр дүн	21,314,108.58	(5,955,530.37)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,247,901.81	2,247,901.81
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>27,048,473.40</b>	<b>21,900,191.03</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>108,610,400.00</b>	<b>78,902,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>24,182,000.00</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	24,182,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,182,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,182,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>84,428,400.00</b>	<b>78,902,700.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	81,428,400.00	78,902,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,428,400.00	78,902,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>87,296,291.42</b>	<b>84,858,230.37</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>87,296,291.42</b>	<b>84,858,230.37</b>

Уянга сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>80,564,342.42</b>	<b>84,606,742.37</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>52,204,274.00</b>	<b>56,320,748.00</b>
210101	Үндсэн цалин	39,245,347.00	42,972,548.00
210104	Урамшуулал	12,958,927.00	13,348,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>6,515,524.00</b>	<b>7,567,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	4,432,232.31	5,465,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	522,172.66	525,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	417,039.34	420,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	99,736.88	105,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,044,342.81	1,050,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,969,503.00</b>	<b>5,784,742.00</b>
210401	Бичиг хэрэг	1,389,680.00	436,750.00
210402	Тээвэр, шатахуун	5,075,500.00	4,996,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	205,823.00	291,692.00
210404	Ном, хэвлэл	298,500.00	60,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>20,000.00</b>	<b>-</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,580,000.00</b>	<b>779,700.00</b>
210602	Тавилга	30,000.00	-
210604	Урсгал засвар	4,550,000.00	779,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>404,000.00</b>	<b>136,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	404,000.00	136,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>717,312.00</b>	<b>382,458.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	243,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	78,312.00	70,958.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	254,000.00	150,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	29,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	120,000.00	132,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,153,729.42</b>	<b>13,635,394.37</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,949,150.00	7,516,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	970,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,904,579.42	5,148,594.37
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,731,949.00</b>	<b>251,488.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>675,000.00</b>	<b>229,800.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	675,000.00	229,800.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,056,949.00</b>	<b>21,688.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,056,949.00	21,688.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>21,314,108.58</b>	<b>(5,955,530.37)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>21,314,108.58</b>	<b>(5,955,530.37)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	19,286,000.00	2,247,901.81	5,484,571.59	0.00	27,018,473.40
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,286,000.00	2,247,901.81	5,484,571.59	0.00	27,018,473.40
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,286,000.00	2,247,901.81	5,484,571.59	0.00	27,018,473.40
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	19,286,000.00	2,247,901.81	5,484,571.59	0.00	27,018,473.40
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,286,000.00	2,247,901.81	5,484,571.59	0.00	27,018,473.40
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-5,955,530.37	0.00	-5,955,530.37
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,286,000.00	2,247,901.81	-470,958.78	0.00	21,062,943.03

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>84,428,400.00</b>	<b>78,902,700.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>84,428,400.00</b>	<b>78,902,700.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	81,428,400.00	78,902,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,428,400.00	78,902,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>84,406,712.00</b>	<b>78,924,388.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>84,406,712.00</b>	<b>78,924,388.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>77,674,763.00</b>	<b>78,672,900.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	52,174,274.00	56,071,500.00
210101	Үндсэн цалин	39,215,347.00	42,723,300.00
210104	Урамшуулал	12,958,927.00	13,348,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	6,515,524.00	7,567,700.00
210201	Тэтгэврийн даатгал	4,432,232.31	5,465,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	522,172.66	525,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	417,039.34	420,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	99,736.88	105,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,044,342.81	1,050,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,969,503.00	5,226,742.00
210401	Бичиг хэрэг	1,389,680.00	436,750.00
210402	Тээвэр, шатахуун	5,075,500.00	4,438,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	205,823.00	291,692.00
210404	Ном, хэвлэл	298,500.00	60,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	20,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,580,000.00	758,500.00
210602	Тавилга	30,000.00	-
210604	Урсгал засвар	4,550,000.00	758,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	404,000.00	136,000.00
210702	Дотоод албан томилолт	404,000.00	136,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	717,312.00	382,458.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	243,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	78,312.00	70,958.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	254,000.00	150,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	29,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	120,000.00	132,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,294,150.00	8,530,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,994,150.00	7,560,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	970,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,731,949.00</b>	<b>251,488.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	675,000.00	229,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	675,000.00	229,800.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	6,056,949.00	21,688.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,056,949.00	21,688.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>21,688.00</b>	<b>(21,688.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	21,688.00	(21,688.00)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	21,688.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	21,688.00	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		21,688.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	78,902,700.00	78,902,700.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	78,902,700.00	78,902,700.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	78,672,900.00	78,672,900.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	56,071,500.00	56,071,500.00
210101	Үндсэн цалин	42,723,300.00	42,723,300.00
210104	Урамшуулал	13,348,200.00	13,348,200.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,567,700.00	7,567,700.00
210201	Тэтгэврийн даатгал	5,465,800.00	5,465,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	525,500.00	525,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	420,400.00	420,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	105,100.00	105,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,050,900.00	1,050,900.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,226,750.00	5,226,742.00
210401	Бичиг хэрэг	436,750.00	436,750.00
210402	Тээвэр, шатахуун	4,438,300.00	4,438,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	291,700.00	291,692.00
210404	Ном, хэвлэл	60,000.00	60,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	758,500.00	758,500.00
210604	Урсгал засвар	758,500.00	758,500.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	136,000.00	136,000.00
210702	Дотоод албан томилолт	136,000.00	136,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	382,450.00	382,458.00
210803	Даатгалын үйлчилгээ	70,950.00	70,958.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,500.00	150,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,000.00	29,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,000.00	132,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,530,000.00	8,530,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,560,000.00	7,560,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	970,000.00	970,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	229,800.00	229,800.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	229,800.00	229,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	229,800.00	229,800.00
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	21,688.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэл байхгүй

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Уянга сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Р.Энхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Уянга сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймгийн Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Уянга сумын ИТХ нь нутаг дэвсгэрийн эдийн засаг нийгмийн асуудлыг хуулийн хүрээнд хариуцаж, бие даан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ИТХ-н 2021 оны 01-02 өдрийн А/02 тоот тушаалаар байгууллагын дотоод хянагтын нэгж нь 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, үйл ажиллагаандаа ЗГ-н 2011-11-09 өдрийн 311 тоот нийтлэг журмыг баримтлан ажиллаж байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Уянга сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 84858.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 848.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувь буюу 678.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө болон бараа материалын тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгөд тайлант онд өөрчлөлт ороогүй байна.
- Бараа материал оны эхнээс 22.0 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 83638.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 78902.7 мянган төгрөгөөр батлагджээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайланд оны төсөв 78902.7 мянган төгрөгөөр батлагдаж, 78902.7 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн ба гүйцэтгэл 78924.4 мянган төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилт орж ирээгүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

### **3.8 Аудитын гол асуудал**

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэхэд ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлаас 257.1 мянган төгрөгийг цалингийн зардалд зориулалт бус зарцуулсан зөрчил илэрлээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Уянга сумын ИТХ нь шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 125 мэдээллийг хугацаанд нь, хугацаа болоогүй 1 мэдээлэл, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар НББ-ийн тухай хуулийн 13-н 5-д "анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13-н 7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 257.1 мянган төгрөгийн алдаа илэрсэн.

##### 4.1 Залруулга

Залруулга байхгүй.

##### 4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

##### 4.3 Албан шаардлага

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлаас 257.1 мянган төгрөгийг цалингийн зардалд зориулалт бус зарцуулсан зөрчилд албан шаардлага өгсөн.

##### 4.4 Зөвлөмж

Зөвлөмж байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Уянга сумын ИТХ	1	257.1					1	257.1		

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Р.ЭНХЗУЛ